

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 4 сарын 29-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

Крипто Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2026 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сэнтрал Тауэр, 17 давхарт 11:00 цагт эхлэв.

Хурлыг нээж: Крипто Үндэстэн ХК-ийн Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил хувьцаа эзэмшигчдэд хандан мэнд дэвшүүлж, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээв.

Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил Хурлын дэгийн дагуу тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэлийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг танилцуулахыг урив.

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл:

Крипто Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 2026 оны 4 сарын 29-ний өдрийн 1 тоот тогтоолыг танилцуулав.

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дугаар хэсэг болон 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн нийт гаргасан 113,212 ширхэг энгийн хувьцаа байна. Үүнээс саналын эрхтэй 101,899 ширхэг энгийн хувьцаанаас 63,754 ширхэг буюу 62.57 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна.
2. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр хэсгийг үндэслэн тус хурал хүчин төгөлдөр болно.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Өнөөдрийн хурлын ирц хуулийн шаардлага хангаж байгаа тул Крипто Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаа эхлүүлье. Хувьцаа эзэмшигчдэд хурлын дэгийг танилцуулав. Өнөөдөр дараах асуудлуудыг хэлэлцүүлэх болно. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

3. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
6. ТУЗ-ийн 2026 оны зардлын төсөв батлах;

Хэлэлцэх асуудал -1

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

2025 он бол крипто зах зээлийн хувьд түүхэн шилжилтийн жил байлаа.

Юуны өмнө, Bitcoin 100,000 ам.доллар давж, шинэ дээд түвшинд хүрсэн нь зах зээл зөвхөн өсөлтийн тухай биш, харин итгэлцлийн шинэ түвшинд хүрснийг харуулсан.

Энэ удаагийн өсөлт нь өмнөх циклүүдээс ялгаатай - retail биш, харин институцийн хөрөнгө оруулагчид зах зээлийг удирдаж эхэлсэн.

BlackRock, Fidelity зэрэг том сангуудын ETF-үүдээр дамжин их хэмжээний хөрөнгө крипто руу орж ирсэн нь зах зээлийг илүү тогтвортой, урт хугацааны чиглэлтэй болгож байна.

Хоёрдугаарт, технологийн тал дээр маш том ахиц гарлаа.

Ethereum болон Layer 2 шийдлүүд хөгжиж, хэрэглээ бодитоор нэмэгдэж байна.

Solana зэрэг өндөр хурдтай сүлжээнүүд хэрэглэгч татах тал дээр хүчтэй өрсөлдөж байна.

Мөн хамгийн чухал шинэ чиг хандлага бол Real World Asset буюу бодит хөрөнгийг токенчлох явдал юм.

Энэ нь крипто зах зээлийг зөвхөн trading-аас гаргаж, санхүүгийн бодит экосистемтэй холбож байгаа том алхам болж байна.

Тиймээс 2025 оныг бид хүчтэй өсөлтийн жил, харин 2026 оныг зах зээлийн тогтворжилт, дараагийн шатанд шилжих үе гэж харж байна.



Санхүүгийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	2023 Q4	2024 Q4	2025 Q4	YOY
ХӨРӨНГӨ				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	995	61,402	570	-99.07%
Дансны авлага	798,767	54,208	255,208	370.79%
Бусад санхүүгийн хөрөнгө	216,473	200,020	200,020	-0.50%
Урьдчилж төлсөн зардал	278,206	292,468	97,042	-66.82%
Бусад эргэлтийн хөрөнгө	4,485,059	8,377,705	7,652,486	-9.21%
Үндсэн хөрөнгө	1,496	1,496	1,496	
Нийт хөрөнгө	5,780,996	8,988,300	8,206,823	-8.69%
ӨР ТӨЛБӨР				
Дансны болон бусад өглөг	609,036	620,997	297,813	-52.04%
Татвар, НД-ын өглөг	3,448	3,450	9,920	187.56%
Богино хугацаат өр төлбөр	612,484	624,447	307,733	-50.72%
Хойшлогдсон татварын өр төлбөр	157,678	427,898	376,033	-12.12%
Урт хугацаат зээл		484,200	601,000	24.12%
Урт хугацаат өр төлбөр	157,678	912,098	977,033	7.12%
Өр төлбөрийн нийт дүн	770,162	1,536,545	1,284,766	-16.39%
ЭЗДИЙН ӨМЧ				
Өмч-хувьцаат	11,321	11,321	11,321	
Нэмж төлөгдсөн капитал	8,421	8,421	8,421	
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,419,104	3,851,076	3,384,294	-12.12%
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	3,464,259	3,464,259	3,464,259	
Хуримтлагдсан ашиг алдагдал	107,728	116,677	53,761	-53.92%
Эздийн өмчийн дүн	5,010,834	7,451,755	6,922,057	-7.11%
Нийт өр төлбөр ба эздийн өмч	5,780,996	8,988,300	8,206,823	-8.69%

Орлогын дэлгэрэнгүй тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	2023 Q4	2024 Q4	2025 Q4	YOY
ОРЛОГО				
Бусад орлого	47,787	62,622	11,545	-81.56%
Хүүгийн орлого	-	-	-	-
Нийт орлого	47,787	62,602	11,545	-81.56%
ЗАРДАЛ				
Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	143,486	91,475	266,599	191.45%

Санхүүгийн зардал	-	66,225	117,831	77.93%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-	-	-
Бусад олз (гарз)	7,464	104,026	309,970	197.97%
Нийт зардал	136,023	53,674	74,461	38.73%
Татварын өмнөх ашиг (алдагдал)	-88,235	8,948	-62,915	-803.11%
Орлогын татварын зардал	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-88,235	8,948	-62,915	-803.11%
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Нийт дэлгэрэнгүй ашиг (алдагдал)	-88,235	8,948	-62,915	-803.11%

Зардлын задаргаа

ҮЗҮҮЛЭЛТ	2023 Q4	2024 Q4	2025 Q4	YOY
ОРЛОГО				
Бусад орлого	47,787	62,622	11,545	-81.56%
Хүүгийн орлого	-	-	-	-
Нийт орлого	47,787	62,602	11,545	-81.56%
ЗАРДАЛ				
Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	143,486	91,475	266,599	191.45%
Санхүүгийн зардал	-	66,225	117,831	77.93%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-	-	-
Бусад олз (гарз)	7,464	104,026	309,970	197.97%
Нийт зардал	136,023	53,674	74,461	38.73%
Татварын өмнөх ашиг (алдагдал)	-88,235	8,948	-62,915	-803.11%
Орлогын татварын зардал	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-88,235	8,948	-62,915	-803.11%
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Нийт дэлгэрэнгүй ашиг (алдагдал)	-88,235	8,948	-62,915	-803.11%

Арилжааны мэдээ

Огноо	Нээлт	Дээд	Хаалт	Нийт арилжааны дүн	Жигнэсэн дундаж ханш	Нийт арилжсан ширхэг
-------	-------	------	-------	--------------------	----------------------	----------------------


2021	₮874.92	₮224,300	₮164,900	₮ 2.5 тэрбум	₮ 61,507.83	41,974
2022	₮164,800	₮164,800	₮90,720	₮ 420.4 сая	₮ 104,263.8	4,033
2023	₮90,000	₮90,000	₮52,000	₮ 534.6 сая	₮ 65,340.50	8,182
2024	₮69,000	₮77,800	₮77,450	₮ 793.0 сая	₮ 48,691.07	16,286
2025	₮77,400	₮77,500	₮46,400	₮ 66.3 сая	₮ 48,490.28	1,367

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

№	НЭР	2024.12.31	2025.12.31	2026.04.10	ХУВЬ
1	Ард Даатгал ХК	25,625	25,979	25,979	22.95%
2	Ард Бит ХХК	10,601	11,292	11,313	9.99%
3	Ардын Тэтгэврийн Данс ХХК	9,884	9,884	9,884	8.73%
4	И Ай Ти ХХК	9,631	9,631	9,631	8.51%
5	Эй Ай Групп ХК	5,856	5,856	5,856	5.17%
6	С.Оргодол	5,025	5,025	5,025	4.44%
7	Үндэсний Хувьчлалын Сан ХОС	3,258	3,258	3,258	2.88%
8	Хаан Банк Кастодиан	2,610	2,610	2,610	2.31%
9	Ц.Энх-Амгалан	2,078	2,078	2,078	1.84%
10	Э.Хасар	2,021	2,021	2,021	1.79%
11	А. Тулга	2,020	2,020	2,020	1.78%
12	Монгол Дифай ХХК	1,987	1,987	1,987	1.76%
13	Ч.Ганхуяг	1,875	1,875	1,875	1.66%
14	Бусад 2,183 хувьцаа эзэмшигч	30,741	29,696	29,675	26.21%

Хувьцаа эзэмшигчдийн тоо

Огноо	Хувьцаа эзэмшигч	Өөрчлөлт
12/31/2020	26	-
7/12/2021	886	3307.69%
10/18/2021	1,717	93.79%
12/31/2021	2,312	34.65%
8/23/2022	2,569	11.12%
12/31/2022	2,502	-2.61%
4/8/2023	2,505	0.12%
12/31/2023	2,417	-3.54%
6/30/2024	2,373	-1.82%
12/31/2024	2,302	-4.76%
12/31/2025	2,217	-3.69%
4/10/2026	2,196	-0.95%




9



Хөрөнгө оруулалтын багц

ТИКЕР	ХЭМЖЭЭ	БАГЦЫН ЭЗЛЭХ %	2025-12-31-НИЙ ХАНШ (₮)
BTC	8.77	38.17%	2,729,946,945
ETH	8.1	1.20%	85,507,699
stETH	33.54	4.95%	353,756,352
TON	100,000	8.24%	589,694,228
ARDM	1,333,333,333	0.55%	39,600,000
ARDX	64,580,876	45.15%	3,229,043,818
USDT	35,079	1.74%	124,764,076
НИЙТ	-	100%	7,152,313,118

Бусад асуудал



(Handwritten signature)



Энэ зураглалууд маань манай хуучин буюу 2024 онд байсан бүтэц болон одоо, ирээдүйн бүтцийг харуулж байна.

2025 онд ТУЗ-ийн шийдвэрийн дагуу Ард Венчурс компанийг Ард Инвестмент Группт өр төлбөртэй нь хамт шилжүүлсэн байна. Тэгэхээр Ард Бит ХХК-ийн балансаас хувь эзэмшиж байгаа компаниудын хамт хасагдсан байгаа.

2026 онд хийгдэх ажлын төлөвлөгөөнд Монгол Дифай ХХК-ийн 30 хувийг Крипто Үндэстэн ХК-д шилжүүлэхээр яригдаж байна. Шалтгаан нь Монгол Дифай ХХК-ийн бүтцэд Монт буюу монголын хамгийн анхны Стейблкойн, АрдМааний төсөл, авдар хэтэвч зэрэг төслүүд маань багтаж байгаа.

Үүн дээр ач холбогдол өгөөд харвал Крипто Үндэстэн ХК-ийн бүтцэд Монгол Дифай ХХК орвол бүх криптотой холбоотой төслүүдийг Крипто Үндэстэн ХК нэгтгээд явна. Тэгснээр том зургаар нийт эздийн өмч ойролцоогоор 14.5 тэрбум төгрөгт хүрэхээр одоогийн үнэлгээгээр харагдаж байгаа.

Хэлэлцэх асуудал-2

2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

Танилцуулсан: Хүлэгт Хүннү Аудит ХХК Гүйцэтгэх захирал И.Гүррагчаа

Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Хүлэгт Хүннү Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал И.Гүррагчаа байна. Манай компани 2012 онд байгуулагдсан бөгөөд аудит, нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөөний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Крипто Үндэстэн ХК-д 3 дах жилдээ аудит хийж ажиллаж байна.

2025 оны санхүүгийн тайлангийн аудитыг бид 2026 оны 3 сарын 16-ний өдөр гэрээ байгуулан ажиллаж 2026 оны 4 сарын 16 өдөр аудитын тайланг хүлээлгэн өгсөн байна.

Бид, “Крипто Үндэстэн” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

Бид аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн бөгөөд Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийн дагуу компаниас хараат бус ба Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна

Хэлэлцэх асуудал-3

ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Крипто Үндэстэн ХК-ийн ТУЗ нь 2025 онд 7 удаагийн эцнээ саналын хуудсаар 7 тогтоол гаргаж ажилласан байна. ТУЗ нь компанийн 2025 оны Үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг баталж ажилласан байна.

Хэлэлцэх асуудал-4

2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 04 сарын 29-ний өдрийн № тоот тогтоол

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Крипто Үндэстэн ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2026 оны 4 сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Крипто Үндэстэн ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

Хэлэлцэх асуудал-5

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 сарын 16-ний өдрийн №26/01 тоот тогтоол

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, “Крипто Үндэстэн” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.5-ыг удирдлага болгож, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. Компанийн санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааг цаашид хэвийн тогтвортой явуулахтай холбоотойгоор 2025оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй болохыг мэдэгдсүгэй.

2. Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дах хэсэгт зааснаар ногдол ашиг хуваарилахгүй байх тухай асуудлыг нийтэд мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай

Хэлэлцэх асуудал-6

ТУЗ-ийн 2026 оны зардлын төсөв батлах.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Крипто Үндэстэн ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсөв

№	Зардлын төрөл	Давтамж (улирлаар)	Нэгж зардал	Сар	Зардал
1	Бичиг хэрэг, хангамж	4	50,000.00	12	200,000.00
2	Бусад	4	200,000.00	12	800,000.00
Нийт зардал					1,000,000.00

Асуулт хариулт

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Хурлын дэгийн дагуу асуулт хариултын цаг эхэлснийг зарлаж асуултыг заалнаас болон Ард Апп-аар дамжуулж авах талаар мэдээлэл өгөв. Заалнаас асуулт асуугаагүй тул асуулт, харилт дуусав.

Санал хураалт

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Хурлын дэгийн дагуу санал хураалтын цаг эхэлснийг зарвал.

Тооллогын комиссын дарга **Ө.Бямбагэрэл**: Крипто Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 2,3 тоот тогтоолын санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Нийт хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид 11:00 цагаас 11:10 цаг хүртэл ирцийг авсан. Хуралдаанаар **63,754** ширхэг буюу **62.57** хувийн хувьцаа эзэмшигч хуралд оролцсоноос:

1.1. Зөвшөөрсөн: **63,754** ширхэг буюу **100%**

1.2. Татгалзсан: Байхгүй

1.3. Түдгэлзсэн: Байхгүй байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Крипто Үндэстэн ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд "Компанийн тухай" хуулийн 67 дугаар зүйлд заасны дагуу томилогдсон тооллогын комисс гүйцэтгэв.

Тооллогын комисс бүрэлдэхүүнд даргаар Ө.Бямбагэрэл, гишүүдээр: Ч.Даваацэрэн, Б.Эрдэнэбилэг нар ажилласан болно.

Гүйцэтгэх захирал хурлыг хаан үг хэлэв.

Хурал 12 цаг 15 минутад дуусав.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

Б.УРАНЦЭЦЭГ

